

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА- 2024\52\НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2023
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 4/181
танай _____ -ны № _____ -г

ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Э.ТҮВШИНЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 4 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 95,4 хувиар хэрэгжүүлсэн байна

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

019020415

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|-----|-----------------------------------|-----------------|------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 93,305,758.51 | 125,281,625.99 |
| 2 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 19,878,711.66 | 30,370,920.53 |
| 8 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 19,878,711.66 | 30,370,920.53 |
| 9 | Төгрөг | 19,878,711.66 | 30,370,920.53 |
| 10 | Төрийн сангийн харилцах | 19,878,711.66 | 30,370,920.53 |
| 27 | АВЛАГА | 3,400,013.00 | 15,877,018.49 |
| 28 | Ажиллагсадтай холбогдсон авлага | 1,278,813.00 | 23,166.49 |
| 29 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 11,222,826.00 |
| 34 | Бусад авлага | 2,121,200.00 | 4,631,026.00 |
| 35 | Байгууллагаас авах авлага | 2,121,200.00 | 631,026.00 |
| 36 | Хувь хүмүүсээс авах авлага | - | 4,000,000.00 |
| 60 | БАРАА МАТЕРИАЛ | 70,027,033.85 | 79,033,686.97 |
| 61 | Түүхий эд материал | 10,081,459.70 | 9,184,580.36 |
| 63 | Эм боох материал | 10,081,459.70 | 9,184,580.36 |
| 65 | Бэлэн бүтээгдэхүүн | 6,822,478.65 | 12,189,348.19 |
| 66 | Хангамжийн материал | 53,123,095.50 | 57,659,758.42 |
| 67 | Бичиг хэргийн материал | 703,500.00 | 511,500.00 |
| 68 | Аж ахуйн материал | 29,779,970.00 | 32,687,540.00 |
| 69 | Сэлбэг хэрэгсэл | 3,350,000.00 | 605,000.00 |
| 70 | Түлш шатах тослох материал | 661,644.21 | 65,517.51 |
| 72 | Хүнсний материал | 2,445,215.40 | 1,938,655.00 |
| 73 | Бусад хангамжийн материал | 16,182,765.89 | 21,851,545.91 |
| 87 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 520,227,929.89 | 443,509,096.03 |
| 107 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 520,227,929.89 | 443,509,096.03 |
| 109 | Биет хөрөнгө | 517,351,929.89 | 440,633,096.03 |
| 110 | Барилга, байгууламж | 419,840,222.90 | 381,908,082.90 |
| 111 | Хуримтлагдсан элэгдэл | (64,255,726.48) | (78,813,481.36) |
| 112 | Авто тээврийн хэрэгсэл | 76,980,000.00 | 75,160,000.00 |
| 113 | Хуримтлагдсан элэгдэл | (45,079,333.76) | (51,410,000.13) |
| 114 | Машин, тоног төхөөрөмж | 202,119,257.79 | 215,925,086.79 |
| 115 | Хуримтлагдсан элэгдэл | (94,274,763.43) | (121,343,247.85) |
| 116 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 36,617,474.76 | 38,234,474.76 |
| 117 | Хуримтлагдсан элэгдэл | (14,765,131.22) | (19,609,125.87) |
| 123 | Бусад үндсэн хөрөнгө | 46,480.00 | 496,480.00 |
| 124 | Хуримтлагдсан элэгдэл | (19,463.67) | (58,086.21) |
| 126 | Номын фонд | 142,913.00 | 142,913.00 |
| 127 | Биет бус хөрөнгө | 2,876,000.00 | 2,876,000.00 |
| 128 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 129 | Хасагдуулга | (550,000.00) | (550,000.00) |
| 130 | Бусад биет бус хөрөнгө | 2,876,000.00 | 2,876,000.00 |
| 138 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 613,533,688.40 | 568,790,722.02 |
| 139 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 3,050,500.00 | 1,096,404.00 |
| 140 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 3,050,500.00 | 1,096,404.00 |

| | | | |
|-----|--|----------------|-----------------|
| 165 | Өглөг | 3,050,500.00 | 1,096,404.00 |
| 166 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 0.00 | - |
| 167 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 3,050,500.00 | 1,096,404.00 |
| 171 | Бусад өглөг | 0.00 | 0.00 |
| 172 | Байгууллагад төлөх өглөг | 0.00 | 0.00 |
| 215 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 610,483,188.40 | 567,694,318.02 |
| 216 | Засгийн газрын хувь оролцоо | 610,483,188.40 | 567,694,318.02 |
| 217 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 103,436,234.32 | 103,436,234.32 |
| 218 | Өмч: -Төрийн өмч | 103,436,234.32 | 103,436,234.32 |
| 224 | Хуримтлагдсан үр дүн | 301,835,188.03 | 259,046,317.65 |
| 225 | Өмнөх үеийн үр дүн | 301,835,188.03 | 301,835,188.03 |
| 226 | Тайлант үеийн үр дүн | - | (42,788,870.38) |
| 228 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 205,211,766.05 | 205,211,766.05 |
| 232 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН Д | 613,533,688.40 | 568,790,722.02 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|-----|--|----------------|----------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 368,551,433.42 | 656,258,266.28 |
| 76 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 6,609,083.42 | 46,201,924.08 |
| 77 | Нийтлэг татварын бус орлого | 6,609,083.42 | 46,201,924.08 |
| 81 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 6,609,083.42 | 46,151,924.08 |
| 86 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 6,609,083.42 | 46,151,924.08 |
| 92 | Бусад орлого | - | 50,000.00 |
| 111 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 361,942,350.00 | 610,056,342.20 |
| 122 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 260,636,250.00 | 568,830,181.30 |
| 126 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | 260,636,250.00 | 568,830,181.30 |
| 129 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 20,441,600.00 | 41,226,160.90 |
| 130 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 20,441,600.00 | 41,226,160.90 |
| 143 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс | 80,864,500.00 | - |
| 145 | Эрүүл мэндийн даатгалын сангаас | 80,864,500.00 | - |
| 147 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 400,050,141.45 | 635,938,652.29 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 399,482,179.11 | 635,938,652.29 |
| 149 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 399,482,179.11 | 632,503,328.84 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 216,105,271.69 | 352,770,110.41 |
| 151 | Цалин | 119,218,503.34 | 261,728,476.27 |
| 152 | Нэмэгдэл цалин | 54,902,920.08 | 64,186,926.11 |
| 153 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,358,150.00 | 1,470,000.00 |
| 154 | Урамшуулал | 38,625,698.27 | 25,384,708.03 |
| 157 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ши | 21,847,765.19 | 43,672,845.53 |

| | | | |
|-----|---|-----------------|-----------------|
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 14,570,194.79 | 31,619,206.34 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 1,714,258.23 | 2,964,116.98 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 2,062,839.98 | 3,000,979.38 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 315,626.67 | 1,421,736.38 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 3,184,845.52 | 4,666,806.45 |
| 164 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 16,995,237.83 | 36,590,837.45 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 2,093,603.83 | 5,118,636.45 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 14,757,634.00 | 31,132,201.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 144,000.00 | 340,000.00 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 27,363,790.61 | 48,638,379.42 |
| 171 | Бичиг хэргийн материал | 1,039,950.00 | 1,834,600.00 |
| 172 | Тээвэр, шатахууны зардал | 18,447,633.79 | 29,741,326.70 |
| 173 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 880,000.00 | 1,936,000.00 |
| 175 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 826,600.00 | 7,211,000.00 |
| 176 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 6,169,606.82 | 7,915,452.72 |
| 181 | Нормативт зардал | 71,343,137.37 | 60,079,538.07 |
| 182 | Эм | 62,740,445.51 | 44,564,127.67 |
| 183 | Хоол | 8,602,691.86 | 14,325,410.40 |
| 184 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 1,190,000.00 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,377,349.89 | 5,639,500.00 |
| 186 | Багаж хэрэгсэл | 795,000.00 | 132,000.00 |
| 187 | Тавилга | 118,749.89 | - |
| 188 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 263,600.00 | - |
| 189 | Урсгал засвар | 1,200,000.00 | 5,507,500.00 |
| 190 | Томилолт, зочны зардал | 438,000.00 | 1,867,500.00 |
| 192 | Дотоод томилолтын зардал | 438,000.00 | 1,867,500.00 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | - | 1,374,524.00 |
| 196 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | - | 576,000.00 |
| 197 | Даатгалын үйлчилгээний төлбөр | - | 282,960.00 |
| 198 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 318,164.00 |
| 199 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | - | 12,400.00 |
| 202 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний төлбөр | - | 185,000.00 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 43,011,626.53 | 81,870,093.96 |
| 210 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,181,462.00 | 26,599,460.00 |
| 212 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 30,830,164.53 | 55,270,633.96 |
| 224 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 3,435,323.45 |
| 247 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт | - | 3,435,323.45 |
| 250 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 3,435,323.45 |
| 253 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 567,962.34 | - |
| 254 | Дотоод эх үүсвэрээр | 567,962.34 | - |
| 257 | Тоног төхөөрөмж | 567,962.34 | - |
| 268 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=II) | (31,498,708.03) | 20,319,613.99 |
| 276 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V=IV) | 11,270,903.92 | 63,108,484.37 |
| 281 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 11,270,903.92 | 63,108,484.37 |
| 287 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V) | (11,270,903.92) | (63,108,484.37) |
| 288 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | (42,769,611.95) | (42,788,870.38) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|-----|--|----------------|----------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 495,878,850.00 | 598,883,516.20 |
| 77 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 260,636,250.00 | 557,657,355.30 |
| 78 | Нийтлэг татварын бус орлого | - | 50,000.00 |
| 92 | Бусад орлого | - | 50,000.00 |
| 100 | Тусламжийн орлого | 260,636,250.00 | 557,607,355.30 |
| 101 | Хандив тусламж /дотоод/ | 260,636,250.00 | 557,607,355.30 |
| 110 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 235,242,600.00 | 41,226,160.90 |
| 121 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 62,876,500.00 | - |
| 125 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | 62,876,500.00 | - |
| 129 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 20,441,600.00 | 41,226,160.90 |
| 130 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 20,441,600.00 | 41,226,160.90 |
| 143 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжи | 151,924,500.00 | - |
| 145 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 151,924,500.00 | - |
| 147 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 404,243,904.71 | 576,856,447.33 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 404,243,904.71 | 576,856,447.33 |
| 149 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 404,243,904.71 | 573,421,123.88 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 238,610,037.62 | 348,682,054.45 |
| 151 | Үндсэн цалин | 137,411,976.25 | 198,192,319.74 |
| 152 | Нэмэгдэл | 60,000,856.37 | 116,286,822.65 |
| 153 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,398,150.00 | 3,175,000.00 |
| 154 | Үр дүнгийн урамшуулал | 37,799,055.00 | 31,027,912.06 |
| 157 | Ажил олгочоос нийгмийн даатгалд төлөх шимтгэ | 24,846,037.26 | 46,505,254.98 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 16,992,017.62 | 31,386,608.78 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 1,999,419.71 | 3,792,285.20 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,595,995.76 | 3,029,108.00 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 387,027.65 | 755,208.00 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 3,871,576.52 | 7,542,045.00 |
| 164 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 16,995,237.83 | 36,590,837.45 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 2,093,603.83 | 3,907,567.13 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 14,757,634.00 | 32,343,270.32 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 144,000.00 | 340,000.00 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 21,709,100.00 | 34,188,100.00 |
| 171 | Бичиг хэрэг | 562,600.00 | 1,623,600.00 |
| 172 | Тээвэр, шатахуун | 18,424,500.00 | 26,524,000.00 |
| 173 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,222,000.00 | 1,955,000.00 |
| 175 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устга | 1,500,000.00 | 3,042,200.00 |
| 176 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 1,043,300.00 |
| 181 | Нормативт зардал | 74,573,490.00 | 56,532,531.00 |
| 182 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 65,299,890.00 | 39,860,931.00 |
| 183 | Хоол, хүнс | 9,273,600.00 | 13,923,900.00 |
| 184 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 2,747,700.00 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,012,840.00 | 19,426,446.26 |
| 186 | Багаж техник хэрэгсэл | 4,891,640.00 | 4,130,840.00 |
| 188 | Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл | 1,054,200.00 | 2,455,300.00 |
| 189 | Урсгал засвар | 1,067,000.00 | 12,840,306.26 |
| 190 | Томилолт, зочны зардал | 438,000.00 | 1,867,500.00 |

| | | | |
|-----|--|-----------------|-----------------|
| 192 | Дотоод албан томилолт | 438,000.00 | 1,867,500.00 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 1,316,524.00 |
| 196 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 480,000.00 |
| 197 | Даатгалын үйлчилгээ | - | 202,650.00 |
| 198 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 250,384.00 |
| 199 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 94,146.00 |
| 201 | Газрын төлбөр | - | 8,344.00 |
| 202 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | 281,000.00 |
| 208 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,059,162.00 | 28,311,875.74 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,059,162.00 | 28,311,875.74 |
| 221 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 3,435,323.45 |
| 234 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 3,435,323.45 |
| 237 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 3,435,323.45 |
| 250 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 91,634,945.29 | 22,027,068.87 |
| 251 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 261 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 44,673,790.00 | 11,534,860.00 |
| 262 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 44,673,790.00 | 11,534,860.00 |
| 263 | Дотоод эх үүсвэрээр | 44,673,790.00 | 11,534,860.00 |
| 275 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 44,673,790.00 | 11,534,860.00 |
| 278 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (44,673,790.00) | (11,534,860.00) |
| 279 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 303 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 46,961,155.29 | 10,492,208.87 |
| 304 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 7,872,962.10 | 19,878,711.66 |
| 305 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 55,084,117.39 | 30,370,920.53 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|----|--|-------------------------|-----------------------|----------------------|--|
| 0 | ДАНС | 511 | 51300 | 51210+51220 | |
| 9 | 2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 103,436,234.32 | 205,211,766.05 | 301,835,188.03 | 610,483,188.40 |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 103,436,234.32 | 205,211,766.05 | 301,835,188.03 | 610,483,188.40 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.0 | 0.0 | 0 | 0 |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 103,436,234.32 | 205,211,766.05 | 301,835,188.03 | 610,483,188.40 |
| 17 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал | 0 | 0 | (42,788,870.38) | (42,788,870.38) |
| 18 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 103,436,234.32 | 205,211,766.05 | 259,046,317.64 | 567,694,318.02 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| № | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|----|---|----------------|----------------|-----------------|-------|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эх | 0 | 19,878,711.66 | (19,878,711.66) | 0 |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙ | 616,695,500.00 | 588,391,307.23 | 28,304,192.77 | 95.4 |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 616,695,500.00 | 588,391,307.23 | 28,304,192.77 | 95.4 |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 616,695,500.00 | 584,955,983.78 | 31,739,516.22 | 94.9 |
| 5 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 372,909,700.00 | 348,682,054.35 | 24,227,645.65 | 93.5 |
| 6 | Үндсэн цалин | 227,342,800.00 | 198,192,319.64 | 29,150,480.36 | 87.2 |
| 7 | Нэмэгдэл | 104,246,700.00 | 116,286,822.65 | (12,040,122.65) | 111.5 |
| 8 | Унаа, болон бусад нөхөн олговор | 3,351,600.00 | 3,175,000.00 | 176,600.00 | 94.7 |
| 9 | Урамшуулал | 37,968,600.00 | 31,027,912.06 | 6,940,687.94 | 81.7 |
| 11 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төл | 47,878,700.00 | 46,505,254.98 | 1,373,445.02 | 97.1 |
| 12 | Тэтгэврийн даатгал | 32,556,300.00 | 31,386,608.78 | 1,169,691.22 | 96.4 |
| 13 | Тэтгэмжийн даатгал | 3,830,600.00 | 3,792,285.20 | 38,314.80 | 99.0 |
| 14 | ҮОМШӨ ний даатгал | 3,064,200.00 | 3,029,108.00 | 35,092.00 | 98.9 |
| 15 | Ажилгүйдлийн даатгал | 767,700.00 | 755,208.00 | 12,492.00 | 98.4 |
| 16 | Эрүүл мэндийн даатгал | 7,659,900.00 | 7,542,045.00 | 117,855.00 | 98.5 |
| 17 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 40,167,900.00 | 36,590,837.45 | 3,577,062.55 | 91.1 |
| 18 | Гэрэл цахилгаан | 4,099,900.00 | 3,907,567.13 | 192,332.87 | 95.3 |
| 19 | Түлш, халаалт | 35,728,000.00 | 32,343,270.32 | 3,384,729.68 | 90.5 |
| 20 | Цэвэр, бохир ус | 340,000.00 | 340,000.00 | - | 100.0 |
| 22 | Хангамж, бараа материалын зардал | 37,165,800.00 | 37,119,800.00 | 46,000.00 | 99.9 |
| 23 | Бичиг хэрэг | 1,623,600.00 | 1,623,600.00 | - | 100.0 |
| 24 | Тээвэр (шатахуун) | 26,524,000.00 | 26,524,000.00 | - | 100.0 |
| 25 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 2,001,000.00 | 1,955,000.00 | 46,000.00 | 97.7 |
| 27 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,642,200.00 | 3,642,200.00 | - | 100.0 |
| 28 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн | 3,375,000.00 | 3,375,000.00 | - | 100.0 |
| 30 | Нормативт зардал | 56,870,100.00 | 56,532,531.00 | 337,569.00 | 99.4 |
| 31 | Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл | 40,198,500.00 | 39,860,931.00 | 337,569.00 | 99.2 |
| 32 | Хоол, хүнс | 13,923,900.00 | 13,923,900.00 | - | 100.0 |
| 33 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 2,747,700.00 | 2,747,700.00 | - | 100.0 |
| 34 | Эд хогшил худалдан авах | 26,540,300.00 | 25,962,606.26 | 577,693.74 | 97.8 |
| 35 | Багаж, техник, хэрэгсэл | 7,500,000.00 | 7,500,000.00 | - | 100.0 |
| 37 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 2,840,300.00 | 2,455,300.00 | 385,000.00 | 86.4 |
| 38 | Урсгал засвар | 16,200,000.00 | 16,007,306.26 | 192,693.74 | 98.8 |
| 39 | Томилолт, зочны зардал | 1,867,500.00 | 1,867,500.00 | - | 100.0 |
| 41 | Дотоод албан томилолт | 1,867,500.00 | 1,867,500.00 | - | 100.0 |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 2,303,000.00 | 1,316,524.00 | 986,476.00 | 57.2 |
| 45 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 480,000.00 | 480,000.00 | - | 100.0 |
| 46 | Даатгалын үйлчилгээ | 420,000.00 | 202,650.00 | 217,350.00 | 48.3 |
| 47 | Тээврийн хэрэгслийн татвар | 300,000.00 | 250,384.00 | 49,616.00 | 83.5 |
| 48 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 100,000.00 | 94,146.00 | 5,854.00 | 94.1 |
| 50 | Газрын төлбөр | 653,000.00 | 8,344.00 | 644,656.00 | 1.3 |
| 51 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 350,000.00 | 281,000.00 | 69,000.00 | 80.3 |
| 53 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,992,500.00 | 30,378,875.74 | 613,624.26 | 98.0 |
| 54 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,992,500.00 | 30,378,875.74 | 613,624.26 | 98.0 |
| 66 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 3,435,323.45 | (3,435,323.45) | 0.0 |
| 79 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 3,435,323.45 | (3,435,323.45) | 0.0 |
| 82 | Төсвийн захирагчдаас олгосон санхүү | - | 3,435,323.45 | (3,435,323.45) | 0.0 |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ | 596,816,800.00 | 598,883,516.10 | (2,066,716.10) | 100.3 |
| ## | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮ | 41,367,900.00 | 41,226,160.90 | 141,739.10 | 99.7 |
| ## | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүү | 41,367,900.00 | 41,226,160.90 | 141,739.10 | 99.7 |
| ## | ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САН | 555,448,900.00 | 557,657,355.20 | (2,208,455.20) | 100.4 |
| ## | Хандив тусламж /дотоод/ | 555,448,900.00 | 557,657,355.20 | (2,208,455.20) | 100.4 |
| ## | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 19,878,711.66 | (19,878,711.66) | 0.0 |
| ## | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 30,370,920.53 | (30,370,920.53) | 0.0 |
| ## | АЖИЛЛАГСДЫН ТОО | 17.00 | 17.00 | - | 100.0 |
| ## | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| ## | Гүйцэтгэх ажилтан | 11.00 | 11.00 | - | 100.0 |
| ## | Үйлчлэх ажилтан | 5.00 | 5.00 | - | 100.0 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төв нь ард иргэдэд Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн бүх төрлийн чиглэлийн үйл ажиллагаа үзүүлдэг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оныг "Эх хүүхдийг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 4 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 98,2 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус Эрүүл мэндийн төв нь батлагдсан орон 19,8 гүйцэтгэлээр 19,8 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Эрүүл мэндийн тухай хууль,
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

Тус байгууллага 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр сумын Засаг даргын нэрэмжит шалгалтаар 94,0 хувьтай, Төв аймгийн Эрүүл мэндийн газраас хяналт үнэлгээ шинжилгээний шалгалтаар 83,4 хувьтай тус тус дүгнэсэн байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44,742.9 мянган төгрөгөөр буюу 7,3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | /мянган төгрөгөөр/ | | |
|---|--------------------|------------------|------------------|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 19,878,. | 30,370.9 | 10,493.2 |
| Авлага | 3,400.0 | 15,877.0 | 12,477.0 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 70,027.0 | 79,033.7 | 9,006.7 |
| Үндсэн хөрөнгө | 520,227.9 | 443,509.1 | -76,718.8 |
| Нийт хөрөнгө | 613,533.6 | 568,790.7 | -44,742.9 |
| Өр төлбөр | 3,050.5 | 1,096.4 | -1,954.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 610,483.1 | 567,694.3 | -42,788.8 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 613,533.6 | 568,790.7 | -44,742.9 |

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 30,370.9 мянган төгрөг болж өмнөх оноос 10,493.2 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь үйл ажиллагааны мөнгөн зарлага өссөнөөс шалтгаалсан.

Авлага данс 15,877.0 мянган төгрөг болж өмнөх оноос 12,477.0 мянган төгрөгөөр өссөн нь Нийгмийн даатгалын сангаас авах авлага 11,222.8 мянган төгрөг, гэрээт ажлын дуусаагүй үлдэгдлийн авлага 4,000.0 мянган төгрөг, байгууллагаас авах авлага 631.0 мянган төгрөг байна. Тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 9,006.7 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар Аймгийн Эрүүл мэндийн газраас 15,278.2 мянган төгрөгийн эм бараа материал хүлээн авсантай холбоотой. Мөн эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/12 тоот тушаалаар 2,398.7 мянган төгрөгийн аж ахуйн материал акталсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь оны эцэст 443,509.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 76,718.8 мянган төгрөгөөр буурсан нь 55,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий ажилчдын орон сууцыг эргэлтийн эмийн сангийн бүртгэлд шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны дэлгэрэнгүй бүртгэлээс харахад:

- 2,067.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил улсын төсвийн хөрөнгөөр, худалдаж авсан.
- 17,067.0 мянган төгрөгийн 2 машины гараж барьснаас 7,600.0 мянган төгрөг нь орон нутгийн хөгжлийн сангаас үлдэх 9,467.8 мянган төгрөг нь төсвийн хөрөнгөөр хийсэн байна.
- Аймгийн Эрүүл мэндийн газраас 13,805.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэгүй хүлээж авсан.

- 55,270.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,134,158.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 90,087.0 мянган төгрөг нийт зарлагыг 1,224,245.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 1,224,245.3 мянган төгрөгөөр зардлыг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,224,245.3 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,076,989.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 90,087.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,245,9 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос тус тус бүрдүүлсэн ба нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь 1,606,856.6 мянган төгрөг байна.

Төсвийн зардлын гүйцэтгэл 1,407,453.0 мянган төгрөг буюу 87,6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг нийт 199,403.6 мянган төгрөгөөр, үүнээс цалин нэмэгдэл, урамшууллын зардлыг 92,061.5 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой зардлыг 20,745.0 мянган төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардлыг 25,724.6 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 17,531.0 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 19,459.0 мянган төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д | 71802 Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-------|---------------------------------------|------------|-----------|----------|---------|
| 80111 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 41,226.1 | 41,226.1 | | 100% |
| 80302 | Нэг иргэнд ноогдох нормативаар | 313,793.8 | 313,783.0 | 10.8 | 99% |
| 81603 | Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 243,846.5 | 213,503.3 | 30,343.1 | 87,5% |
| 83603 | Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан | 19,895.6 | 19,878.7 | 16.9 | 99% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд нэмэлт санхүүжилтийн данс байхгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|-------------|------------------|---------------------------------------|------------------|-----------------|------------|
| 1 | 71602-80111 | 2023-12-31 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 100% | 41,226.1 | 41,226.1 |
| 2 | 71802-80302 | 2023-12-31 | 1 иргэнд ноогдох нормативаар | 99% | 313,793.8 | 313,783.0 |
| 3 | 71802-81605 | 2023-12-31 | Үндсэн тусламж үйлчилгээ | 87,5% | 243,846.5 | 213,503.3 |
| 4 | 71802-83603 | 2023-12-31 | Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан | 99% | 19,895.6 | 19,878.7 |

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй. Аймгийн Эрүүл мэндийн газраас тендер шалгаруулсан газруудаас эм, эмийн хэрэгсэл боох материалыг нийлүүлдэг. Хүнсний бараа материалыг сумын худалдан авах ажиллагааны газрын зөвшөөрөлтэй Сүмбэр сумын Ди өү эн Ди ХХК-аас нийлүүлдэг байна. Худалдан авах ажиллагааны 2023 оны төлвөлгөөг батлуулж зохих хууль, журмын дагуу гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах анхан шатны бүртгэлийг бүрэн хөтөлж хэвших болон шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Мягмар, аудитор С.Дашдондог нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Релаэнс секюритиз аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 590,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 11,800.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9,500.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хэмнэж ажилласны үр дүнд ажиллагсдад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорх хэмнэлт гаргасан байна. Үүнд :

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 24,227.6 мянган төгрөгөөр
- Байр ашиглахтай холбоотой болон эд хогшил худалдан авах зардлыг 4,154.7 мянган төгрөгөөр
- Хангамжийн бараа материал болон бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг 1,032.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус эрүүл мэндийн төв нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 153 мэдээллийг байршуулж, 6 мэдээлэл хугацаа хоцроосон байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулж, зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн эхний 2023 оны 9 дүгээр сарын 30-наар тасалбар болгосон санхүүгийн тайланд хийгдсэн Завсрын аудитын явцад тооллогын бүртгэлтэй холбоотой болон зардлын данстай холбоотой 8,915.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөгдсөн. Биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 2 зөвлөмж нь хэрэгжээгүй тул аудитын тайланд тусгаж зөрчлөөр оруулсан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|----------------|----------|----------------|------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 1,955.2 | 1 | 1,955.2 | 100 |
| Албан шаардлага | 1 | 6,405.5 | 1 | 6,405.5 | 100 |
| Зөвлөмж | | | | | |
| Нийт дүн | 2 | 8,405.7 | 2 | 8,405.7 | 100 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны зардлын болон эргэлтийн эмийн сангийн цахим төлбөрийн баримтууд татварын цахим системд нэг регистрээр бүртгэгдэж байна. Үүнээс үүдэн эргэлтийн эмийн сангийн орлого, зарлагын гүйлгээний хяналтын тогтолцоо алдагдах эрсдэл үүсэж байгаа асуудлыг дараагийн аудитаар авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,251.8 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 4,000.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 251.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Гэрээт ажлын дуусаагүй үлдэгдэл 4,000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” мөн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.3 Зөвлөмж

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Жолоочийн шатахуун зарцуулалтын тооцоог бодож гаргаагүйн улмаас 251.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1-р хавсралт автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулах жишиг нормыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид жолоочийн бензин зарцуулалтыг нормын дагуу бодож хэрэгжүүлэх

Дээрх төлбөрийн акт, болон зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|-------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------|----------------|---------------|----------------|-----------------|-----|----------|--------------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Гэрээт ажлын дуусаагүй үлдэгдэлийг буцаан төвлөрүүлэх | 1 | 4,000.0 | 1 | 4,000.0 | | | | | | | | |
| Жолоочийн шатахуун зарцуулалтын тооцоог бодож гаргаагүй | 1 | 251.8 | | | | | 1 | 251.8 | | | | |
| Дүн | 2 | 4,251.8 | 1 | 4,000.0 | | | 1 | 251.8 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--|--|--|--|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | | | | |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| 159 мэдээ оруулахаас 6 мэдээ хоцроосон | 1 | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |
| Нийт дүн | 1 | | | | | | | | | | | |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn